

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Онц байдал, дайн бүхий болон дайны байдал, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд асуудлыг цахим хуралдаанаар хэлэлцүүлж болно.”

2/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл. Цахим хуралдааны дэг

6¹.1. Нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг /Цаашид “хуралдаан” гэх/ цахим хурлын программ ашиглан зохион байгуулна. Цахим хурлын программ нь гишүүд, ажлын хэсэг байршлаас үл хамааран дүрсээ харан нэгэн зэрэг сонсох болон ярих боломжтой байна.

6¹.2. Хуралдааны зарыг албан ёсны цахим шуудан болон холбооны хэрэгсэл ашиглан Улсын Их Хурлын гишүүнд мэдэгдэнэ.

6¹.3. Тухайн өдрийн хуралдааны товлосон цагаас 1-ээс доошгүй цагийн өмнө цахим хурлын программыг идэвхжүүлж гишүүний ирцэд бүртгүүлэх боломжийг хангасан байна.

6¹.4. Хэлэлцэх асуудлын материалыг албан ёсны цахим шуудангаар илгээж, Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулна.

6¹.5. Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.4-т заасан Зөвлөлийн гишүүд биечлэн, бусад гишүүн төрийн ордон дахь хуралдааны танхим, эсхүл албан өрөөнөөсөө оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн бол тухайн байгаа газраасаа цахим хуралдааныг хэвийн явуулах боломж, нөхцөлийг хангаж оролцоно.

6¹.6. Хуралдаанд тухайн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсэг, Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох ажилтнууд оролцож болно.

6¹.7. Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд цахим хурлын программ ашиглаж, оролцсон гишүүнийг хуралдаанд хүрэлцэн ирснээр тооцож, хуралдааны ирцэд бүртгэнэ.

6¹.8. Хуралдааны ирцэд бүртгүүлсэн гишүүн тухайн хуралдаанаас албан ёсоор чөлөө аваагүй, Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн

асуудал хэлэлцсэн гэж бүртгэлээс гарахаа өөрөө мэдэгдэж, цахим хуралдаанаас гараагүй тохиолдолд түүнийг хуралдааны ирцэд тооцон, тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.

6¹.9.Хуралдааны үед нам, эвслийн бүлэг тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авахаар бол хуралдаан даргалагч асуудлыг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан завсарлагын хугацааг тогтооно.

6¹.10.Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд үг хэлж, байр сууриа илэрхийлэх, тайлбар хийх, асуулт асуухдаа цахим хурлын программын мэдээлэл солилцох хэсэгт бичвэр томъёоллоор мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр микрофон нээгдэхэд үг хэлж, асуулт асууна.

6¹.11.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хуралдаан даргалагч санал хураалтын цагийг урьдчилан мэдэгдэнэ.

6¹.12.Санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим хурлын программын мэдээлэл солилцох хэсэгт саналаа өгөх хэлбэрээр явуулна. Санал хураалтын дүнг хуралдаан даргалагч нэгтгэн танилцуулна.

6¹.13.Хуралдааны дэг зөрчсөн болон цахим хурлын программын мэдээлэл солилцох хэсэгт хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй үг бичих, цахим хуралдааныг хэвийн явуулахад саад учруулсан үйлдэл гаргавал гишүүнд хуралдаан даргалагч сануулах, сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдаанд, эсхүл тухайн хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хасах, цахим программын мэдээлэл солилцох хэсэгт бичих, үг хэлэх эрхийг нь 3 цаг хүртэл хугацаагаар хасаж, энэ тухай мэдэгдэнэ.

6¹.14.Цахим хуралдаанд энэ хуулийн 9¹.2 дахь заалтыг баримтлахгүй.

6¹.15.Хуралдааны явцыг дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад техник хэрэгсэл ашиглан хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас бэхжүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.22 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.2.22.Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг